



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 24 өдөр

Дугаар 11/19

Шивээговь сум

Төрийн албан хаагчдын цалинг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн “Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 82 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/43 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Монгол улсын Засгийн газраас Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтнуудын үндсэн цалин болон орон нутгийн нэмэгдлийг шинэчилж, хавсралтаар баталсугай.

2. Төрийн албан хаагчдын шинэчлэгдсэн цалин болон бусад нэмэгдлийг хууль, журмын дагуу бодож 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн олгохыг Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч (Г.Бум-Аюуш), Соёлын төвийн нягтлан бодогч (У.Чулуунцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн Б/04 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

Сумын Засаг даргын 2025 оны 01 дугаар
сарын 04-ний өдрийн 01/19 дугаар
захирамжийн хавсралт



ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УДИРДАХ АЛБАН
ТУШААЛТНУУДЫН ҮНДСЭН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ

№	Овог, нэр	Албан тушаал	Албан тушаалын ангилал, зэрэглэл	Үндсэн цалин	Орон нутгийн нэмэгдэл
1	П.Ганчимэг	Эрүүл мэндийн төвийн дарга	ТҮЭМ-6	1,559,000	Улсын төсвөөс 40%
2	-	Соёлын төвийн дарга	ТҮСБ-5	1,637,000	Улсын төсвөөс 40%